

**ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСТОЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2016 он

АГУУЛГА

- I. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
- II. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ
- III. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
- IV. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
- V. ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ
- VI. ДҮГНЭЛТ
- VII. САНАЛ

I. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Олон улсын гэрээ, баримт бичгүүд цөөнгүй батлагдсан.

НҮБ-ын ивээл доор 81 улс орон оролцон “Мансууруулах эмийн тухай Нэгдсэн конвенц¹-ийг 1961 оны 3 дугаар сарын 25-ний өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13-ний өдөр хүчин төгөлдөр болсон, 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулж, уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон.²

Уг конвенц нь мансуурал үүсгэх чадвартай бодисууд болох опоид, каннабиноид ба кокаиныг хууль бусаар үйлдвэрлэх, дамлан худалдаалах, хууль бусаар ашиглах зэрэг 51 заалт бүхий олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг юм.

Энэхүү мансууруулах бодис агуулсан ургамлыг тарималжуулахыг хязгаарлаж, хяналт тавих системийг бий болгожээ.

1961 оны конвенцид нэгдэн орсон талууд мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй гэж үзсэн бодис, эм бэлдмэлийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад нэн даруй хүргэх үүрэгтэй.

Энэ конвенцийн 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний эргэлтийг **хууль ёсны болон хууль бус** гэж ангилж үндэслэлийг бүрдүүлж өгчээ. Конвенцийн 2 дугаар зүйлд хяналтанд хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналтанд байна” гэж заажээ.

Мөн зүйлийн 5 дахь хэсэгт “гэрээнд нэгдэн орсон талууд нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлгийн болон эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглахаас бусад зорилгоор мансууруулах бодисыг худалдаалахыг хориглохоор” заасан байна. Уг конвенциор үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хувиарлах болон ашиглах явдлыг хязгаарлаж, хууль бус эргэлтийн аливаа хэлбэрийг хориглосон юм. Энэхүү конвенцид заасан журмын дагуу мансууруулах бодисын олон улсын худалдаа нь Мансууруулах бодист хяналт тавих олон улсын хорооны хяналтанд байхаар заасан байна.

“Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенци³ 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Вена хотноо 71 орны төлөөлөгчид оролцон баталж 1976 оны 8 дугаар сарын 16-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.⁴

Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголт⁵ тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэдгийг зааглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Конвенцийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч тал нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах илүү тохиромжтой арга гэж үзвэл эмнэлгийн болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд шаардлагатайгаас бусад тохиолдолд түүнийг худалдаалахыг хориглох”⁶ тухай тусгаснаас гадна хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналт дор байна” гэжээ.

Уг конвенциор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан юм. Энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм.

¹ UN United Convention on narcotic drugs, 1961 – Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон.

² Монгол улс 1990.12.06-нд нэгдэн орсон. Төрийн мэдээлэл тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 957-996 дахь тал

³Энэ конвенцийг Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

⁴Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон. “Төрийн мэдээлэл” тусгай дугаар 4 дүгээр боть, 2006, 1033-1063 дахь тал

⁵ Дурьдсан конвенци. 5 дахь тал

⁶ Мөн тэнд

Монгол Улсын 2001 онд нэгдэн орсон НҮБ-ын 1988 оны “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенцийн агуулга нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэхэд байнга хэрэглэгддэг угтвар бодис, түүхий эд, урвалуудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хяналтанд авах асуудлын олон улсын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршжээ.

Түүнчлэн, энэхүү конвенц нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнээс олох ашиг орлогыг олон улсын хяналтанд авах, хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлтээс олсон ашиг орлого, эд хөрөнгийг хураан авах, энэ төрлийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг бүрдүүлэх, гэмт хэргийг шалгах явцад талууд эрх бүхий байгууллагуудаараа дамжуулан бие биедээ эрх зүйн өргөн туслалцаа үзүүлэх зэрэг боломжийг бүрдүүлж өгчээ. Тухайлбал: Конвенцийн 7-р зүйлд мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэм хэргийг шалгах явцад талууд бие биедээ эрх зүйн өргөн туслалцаа үзүүлэх бөгөөд уг туслалцаа нь нотлох баримт цуглуулах, байцаах нэгжих болон баривчлах ажиллагаа явуулах, тодорхой эд зүйл, газарт үзлэг хийх, мэдээлэл олж авах зэрэгтэй холбоотой байхаар заажээ.

Үүнээс гадна, дээрх конвенцийн “Эрх зүйн зөрчил ба үр дагавар” гэсэн 3-р зүйлийн 1 дэх хэсэгт “талууд нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдах, нийлүүлэх энэ талаар санал тавих, дурын нөхцөлтэйгөөр нийлүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцох талаар арга хэмжээ авна” гэж заан хууль бус эргэлт байж болох бүх хэлбэрийг тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай хуулийн 2.2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан зэргээс үзэхэд Монгол Улс нэгдэн орсон дээрх конвенциуд нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр холбогдох дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Эдгээр конвенцид нэгдэн орсон талууд нь дээрх конвенциудад заасны дагуу тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээдэг талаар өмнө өгүүлсэн билээ. Тухайлбал: НҮБ-ын мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанаас “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцийн 6/ Гэмт хэрэгтэн шилжүүлэх 7/ Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, 17/ Хууль бусаар далайгаар тээвэрлэх зэрэг зүйлүүдэд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий үндэсний байгууллагуудын жагсаалт”-ыг тогтмол хугацаанд нэгтгэн гаргадаг бөгөөд 2003 онд шинэчлэн гаргасан жагсаалтан дээрх конвенцийн 6, 7 –р зүйлд заасан үйл ажиллагааг Монгол Улсын хэмжээнд хариуцан хэрэгжүүлэх үндэсний эрх бүхий байгууллага нь ЭЦГ юм.

2003 оны 07 сарын 04-ны өдөр Вена хотноо Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба/UNODC/-ны хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт холбогдох албаны хүмүүс гарын үсэг зурсан байна.

Уг санамж бичигт: Монгол Улсын мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдалд шуурхай үнэлгээ хийх, мансууруулах бодисын эргэлтэд хяналт тогтооход болон “Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хянаж шинэчлэх, Засгийн газрын холбогдох байгууллага, агентлагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт явуулах, техник хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхлэх албанаас Монгол Улсын Засгийн газарт туслалцаа дэмжлэг үзүүлэхээр болсон байна.

2005.05.16-нд Москва хотноо ОХУ-ын Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны Алба, Монгол Улсын ХЗДХЯам Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” хэлэлцээр байгуулж, хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 2006 оноос эхлэн олон улсын “Канал” нэгдсэн арга хэмжээнд жил бүр ажиглагчаар оролцож байна.

2007 онд "Хил орчмын бус нутгийн хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах" тухай нэмэлт протоколыг батлан, хамтран ажиллах болжээ.

II. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 23-р зүйлд согтуурал буюу мансуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй.

Ийм этгээдэд шүүх ял оногдуулахын зэрэгцээ энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар заасан.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, харгалзан дэмжигч тогтоох журмыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 68 дугаар зүйлд тогтоосон байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуульд Хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх /188-р зүйл/, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах /192-р зүйл/, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих /193-р зүйл/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах /194-р зүйл/, Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах /195-р зүйл/, Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах /196-р зүйл/ зэрэг хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой Эрүүгийн хуулийн 192-196-р зүйлүүдэд заасан гэмт хэргүүдийн талаарх хэм хэмжээ учир дутагдалтай, оновчтой бус, тус хуулийн хэм хэмжээг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбаргүй явж ирсэн зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтэнд сөргөөр нөлөөлж, зарим эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектууд хуулийг буруу хэрэглэх, гэмт хэргийг буруу зүйлчлэх тохиолдол судалгаанаас ажиглагдаж байна⁷. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 192-р зүйлийн объектив талын бэлтгэсэн, олж авсан үйлдлийг нэг мөр ойлгоогүйгээс зарим хэрэг шүүхийн өмнөх шатанд хэрэгсэхгүй болж, манай орны тодорхой газар нутагт байгалийн жамаар ургаж байгаа зэрлэг олс (каннабис)-ыг хэн нэгэн этгээд түүж аваад будаг шингэлэгч зэрэг ямар нэгэн химийн бодистой хольж мансууруулах бэлтгэл хангасан үйлдэл дээр зөвхөн бэлтгэсэн объектив үйлдэл нь эрүүгийн зүйлчлэлд багтаж байна.

Байгалийн жамаар ургаж байгаа каннабисыг түүж аваад, цайруулж, ургамлаас нь мансууруулах хүч ихтэй цэцэг, давирхайг нь салгаж аваад, дараа нь өөр төрлийн эм, химийн бодистой хольж үнэрлэх, тамхинд хольж утааг уушиглан сороход бэлтгэсэн үйлдлүүдийг бэлтгэх, үйлдвэрлэх гэж 2 объектив шинжээр нь салгаж Эрүүгийн хуульд хуульчлаагүй нь энэ төрлийн гэмт хэргийг байгалийн жамаар ургаж байгаа ургамлыг олж авсан гэдгээр зүйлчилж, гэмт этгээдэд ял завшуулах, улмаар гэмт хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаагаар шийдвэрлэхэд шууд ба шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13¹-р зүйлд “Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан согтуурах, мансуурах донтой ... биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил гаргасан бол 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулж болох бөгөөд энэ хугацаанд дээр дурдсан этгээдийн талаар эмнэлгийн дүгнэлт гаргуулах, албадан эмчлүүлэх тухай материалыг бүрдүүлж холбогдох байгууллагад шилжүүлнэ” гэж хуульчилсан.

Байгалийн ургамлын тухай хуулийн 20-р зүйлд “Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлана. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож, тэдгээрийг тусгай бүртгэлд

⁷ Цагдаагийн Ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн. “Хар тамхины гэмт явдлын шалтгаан, нөхцөл, санал, зөвлөмж” судалгааны тайлан, УБ.,2012

бүртгэнэ. Түүнчлэн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно”⁸ гэж заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2-р зүйлд “Даатгуулагч ...согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг санаатай зөрчсөний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд түүнд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй”, Эмийн тухай хуулийн 16¹-р зүйлд зааснаар, Монгол улсад хэрэглэгдэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт, худалдах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, худалдах, тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу олгож, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

Согтуурах, мансуурах донтой⁹ өвчтэй хүнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх үйл ажиллагааг 2000 оны хуулиар зохицуулж байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, тэмцэх зорилгоор Улсын Их Хурлаас 2002 оны 11-р сарын 28-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” бие даасан хууль батлан гаргасан нь энэ төрлийн бодисын эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Энэ хуульд зааснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хуульд тогтоосон үйл ажиллагааг хэлнэ” гэж тайлбарлажээ.

2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Монгол улсын Их хурлаас баталж, 2016 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс хэрэгжих байсан эрүүгийн хуулийн шинэчилсэн найрууллагын олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэсэн 20 дугаар бүлэгт **Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /20.7 дугаар зүйл/, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах /20.8 дугаар зүйл/, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших /20.9 дүгээр зүйл/, Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах /20.10 дугаар зүйл/ зэрэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 4 төрлийн гэмт хэргийн хуульчилсан нь өмнөх хуульд байсан алдаатай болон хийдэлтэй зохицуулалтыг засах, зарим нэр томъёог тайлбарлах, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцийн заалтуудыг үндсэний хууль тогтоомжинд нийцүүлэхэд зарим талаар дэвшилттэй алхам болсон байна.**

III. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолуудыг судалж үзэхэд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлсэн хэрэгт ял оногдуулсан 3 хүн мансууруулах үйлчилгээ бүхий каннабис /Тетра гидро каннабинол/ бодис агуулсан, хагас боловсруулсан бэлдмэлийг бусдад борлуулах зорилгоор БНХАУ-ын Бээжин хотод бусдаас худалдан авч, Монгол улсад оруулж ирсэн гэж мэдүүлсэн байна.

⁸ Байгалийн ургамлын тухай хууль. УБ.,1995

⁹ “Мансуурах дон” гэж мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгэцийг өвчнийг хэлнэ. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. УБ.,2002

Харин бусад шүүгдэгч нар нь мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг Монгол улсын нутаг дэвсгэр дээрээс олж авсан, тухайлбал, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутгаар ургадаг Каннабисийн төрлийн мансууруулах бодисын агууламжтай ургамлыг түүж, хатааж хэрэглэх, түүнээсээ бусдад өгөх, худалдаалах зэрэг гэмт хэрэг үйлджээ.¹⁰

Нийслэл, дүүргийн шүүхийн **2008-2012** оны эрүүгийн хэргийн нэгдсэн мэдээнээс харахад Эрүүгийн хуулийн 193 дугаар зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих”, мөн Эрүүгийн хуулийн 194 дүгээр зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах”, Эрүүгийн хуулийн 195 дугаар зүйлд заасан “Мансууруулах бодис агуулсан ургамалыг тарих, ургуулах, хурааж авах”, мөн Эрүүгийн хуулийн 196 дугаар зүйлд заасан “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах” гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулсан бүртгэгдээгүй байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг зөв зүйлчлэх, шүүхээр хянан шийдвэрлэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд дараах асуудлууд тулгамдаж буй болох нь судалгааны үр дүнд тодорхойлогдсон. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийг төрлийн объектын шинжээр нь бүлэглэдэг боловч мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдийг тус хуульд оновчгүй хуульчилсан. Тухайлбал, “Хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 21-р бүлгийн 188 дугаар зүйлд, бусад мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг Эрүүгийн хуулийн “Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” гэсэн 22-р бүлгийн 192, 193, 194, 195, 196-р зүйлүүдэд хуульчилсан байна. Иймд хууль зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж буй шинэ Гэмт хэргийн хуулийн төсөлд эдгээр мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдийг оновчтой байдлаар хуульчлах нь зүйтэй.

2. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, борлуулсан” гэмт хэрэг үйлдэгчдээс гэмт хэрэг үйлдсэн шалтгааныг тодруулахад “бусдад уруу татагдаж, сонирхсон, хөгжим гоё сонсогддог, тайвширдаг, онгод ордог, эсхүл өвчнөө намдаах зорилгоор олж авч хэрэглэсэн” гэх тайлбарыг өгсөн байна.

Зарим өмгөөлөгчийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн тайлбар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлагаас харахад каннабисын төрлийн мансууруулах бодисын агууламжтай өвсийг хэрэглэх нь хүний биед тийм ч хор аюултай биш, энэ нь уран бүтээлчид онгод оруулах хэрэгсэл болдог учраас гэмт хэрэг биш мэтээр сөрөг сурталчилгаа хийж үйлчлүүлэгчээ өмгөөлөх явдал гарсан.

Гэтэл мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт нь хүн амын дунд хяналтгүйгээр тархаж, тэдний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, гэр бүл, нийгэм сэтгэл зүйн уур амьсгал, цаашилбал үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, улс төр, нийгмийн дэг журамд сөрөг нөлөө үзүүлдэгт энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюул оршино.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх явдал нь гэмт хэрэг үйлдэгдэх, цаашилбал, зохион байгуулалттай гэмт хэргийн үндэс суурь болдог байна.

Тухайлбал, 2008 онд Чингэлтэй дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 214 тоот шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч 26 настай, рок хөгжим сонирхогч, Ц нь “Тетрагидро каннабинол дельта 9” мансууруулах бодис бүхий олсны төрлийн ургамлыг 2003 оноос хэрэглэн түүндээ донтож, каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон төрх үйлийн эмгэг өвчтэй болсон ба 2007 оны 11 дүгээр сарын 22-нд мансуурсан үедээ

¹⁰“Таны амьдрал-мансууралгүй орчин” онол, практикийн хуралд Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэнгийн тавьсан “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг шүүн таслах практик, тулгамдсан асуудлууд” илтгэлээс

найз охиноо онц харгис хэрцгий аргаар буюу 24 удаа хутгалж алсан гэмт хэргийг үйлджээ.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дээр дурьдсан олон улсын гэрээ, конвенци болон үндэсний хууль тогтоомжид гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай. Үүнд:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 196 тогтоол,
- Эрүүл мэндийн сайдын 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 139/А/148 тоот тушаалаар батлагдсан “Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт”,
- Эрүүл мэндийн сайдын 2003 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 306 тоот тушаалаар батлагдсан “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг нийлүүлэх, үйлдвэрлэх, хэрэглэх журам”

3. Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд “Хар тамхи, мансууруулах, хордуулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих”, “Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл их хэмжээтэйгээр, түүнчлэн албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх”-ээр заажээ. Дээрх гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд заасан хүнд болон онц хүнд гэмт хэргийн ангилалд хамаарч байна.

Харин Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-д “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,

192.2-т Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,

192.3-т Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг:

192.3.1. Онц их хэмжээгээр;

192.3.2. Насанд хүрээгүй хүн оролцуулж;

192.3.3. Онц аюултай гэмт хэрэгтэн;

192.3.4. Давтан;

192.3.5. Урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Эрүүгийн хуулийн дээрх заалтуудаас харахад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг “**хэрэглэх**” нь гэмт хэрэг мөн эсэх талаар Эрүүгийн хуульд тодорхой заалт алга байна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн этгээдийг тухайн бодисыг хууль бусаар олж авсан гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно” гэсэн Эрүүгийн хуулийн 3.2 дахь заалтыг ноцтой зөрчиж байгаа явдал юм.

Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан үйлдлүүд нь тус тусдаа гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулдаг. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1 болон 192.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн диспозиц шинжүүд нь борлуулах зорилго агуулсан эсэхээрээ ялгаатай байх тул гэмт этгээд дээрх 2 зүйл хэсэгт заасан хэргийн аль алиныг үйлдсэн бол эдгээр нь нийлмэл гэмт хэрэг болно.

Гэвч “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “олж авсан” гэдэгт ямар ямар үйлдлийг хамааруулж үзэх нь хуульчдын дунд маргаан өрнүүлж байна. Өөрөөр хэлбэл “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг тухайн этгээд зөвхөн өөрөө биечлэн худалдаж авсныг “олж авсан” үйлдэлд хамааруулна” гэж зарим хуульчид үзэж байна.

Тэгвэл онолын хувьд **“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг олж авсан”** гэдэгт түүнийг худалдан авсан, эсхүл ямар нэг үүргийн гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлсний төлбөрт, эсхүл өрөндөө тооцож авсан, ямар нэг эд зүйлээр сольж авсан үйлдлийг хамааруулан ойлгохоос гадна гээгдсэн мансууруулах бодисыг олж аван өөрийн болгосон, мөн мансууруулах бодис агуулсан зэрлэг ургамлыг түүж авсан зэрэг үйлдлүүдийг ойлгох бөгөөд түүнийг эзэмшилдээ авч, захиран зарцуулах бодит боломж үүссэн үеэс гэмт хэрэг төгссөнд тооцно. Харин мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис олж авахаар бусдад мөнгө өгсөн боловч түүнээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас авч чадаагүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзэх нь зүйтэй.

4. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг **“хадгалсан”** үйлдэл нь үргэлжилсэн үйлдэлд хамаарах ба гэмт хэрэг илэрснээр төгссөнд тооцно. Ямар хугацаанд хадгалсан нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

5. Энэ төрлийн хэргийг зүйлчлэхэд шинжээчийн дүгнэлтийг үндэслэхээс гадна мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисын хэмжээг анхаарах ёстой. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 192.1 дэх хэсэгт “хэмжээ”-г зааж өгөөгүй тул хүний биед мансууруулах үйлчилгээ үзүүлж чадах тухайн бодисын доод хэмжээнээс “онц их хэмжээ” хүртэлх хэмжээг хамааруулан ойлгох ба “онц их хэмжээтэй” бол хэргийг Эрүүгийн хуулийн 192.3.1-д зааснаар хүндрүүлэн зүйлчилнэ.

Эрүүгийн хуулийн 192.3.1-д заасан **“Онц их хэмжээ”**-г ямар шалгуураар тогтоох, энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хохирлын хэмжээг шалгуур болгон хэрэглэх боломжтой эсэх нь хуульд тодорхой биш байна.

Иймд НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос гаргасан зөвлөмжөөс гадна тухайн хэрэг, тохиолдол бүрт мансууруулах бодисын хэмжээ, хүнд үзүүлэх үйлчилгээний шинж чанарыг харгалзан хэмжээг тогтоох шаардлагатай. Тухайлбал, гэмт этгээдээс 0.1-0.3 гр хэмжээтэй гашиш хураан авсан тохиолдолд НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос гаргасан хүснэгтийг үндэслэн хэргийг Эрүүгийн хуулийн 192.1-д зааснаар зүйлчлэх боломжтой боловч гашишт агуулагдах тетра гидро каннабинолын хэмжээ нь хүний биед ямар нэг мансууруулах үйлчилгээ үзүүлэх чадваргүй тул тухайн мансууруулах бодисын хүнд үзүүлэх үйлчилгээний шинж чанараас гадна тухайн бодист агуулагдах мансууруулагчийн хэмжээний талаар гаргасан шинжээчийн дүгнэлтийг үндэслэн хэргийг шийдвэрлэх нь зүйтэй.

Онц их хэмжээ нь тухайн мансууруулах бодисын төрлөөс хамаарч янз бүр байж болно. НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос гаргасан зөвлөмж дараах хэмжээг тогтоож өгсөн байдаг. Үүнд:

- Хатаасан марихуан 500 граммаас дээш
- Хатаагаагүй марихуан 2.5 кг-аас дээш
- Гашиш 100 граммаас дээш
- Гашишийн масло 50 граммаас дээш
- Экстракционный опий 10 граммаас дээш
- Ацелированный опий 5 граммаас дээш
- Хатаасан “макавая солома” 250 граммаас дээш
- Хатаагаагүй “макавая солома” 1,25 граммаас дээш
- Морфин 1 граммаас дээш
- Героин 0,0005 граммаас дээш

- Гар аргаар бэлтгэсэн эфедриний бэлдмэл 100 мл-ээс дээш гэх мэт

6. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан үйлдлүүд нь бусдад борлуулах зорилго агуулсан тохиолдолд хэргийг Эрүүгийн хуулийн 192.2-т зааснаар зүйлчлэхээр хууль тогтоогч заасан байна.

Гэвч Эрүүгийн хуулийн 192.2-т заасан гэмт хэргийн диспозициос үзэхэд “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг борлуулах зорилго агуулаагүй боловч хууль бусаар тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэлд Эрүүгийн хариуцлагад татах боломжтой эсэх нь ойлгомжгүй, “борлуулах зорилго” нь “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэлд хамаарах эсэх талаар хуульчид маргаж болохоор байна.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 228 дугаар зүйлд борлуулах зорилго агуулаагүй боловч мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэлд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэл нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг нэмэгдүүлэх, мансууруулах бодис хяналтгүйгээр тархах, хэрэглээг нэмэгдүүлэх гол нөхцөл болох тул энэ талаар хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн хэн нэгэн этгээд өөрөө хэрэглэх зорилгоор мансууруулах үйлчилгээтэй бодисыг хууль бусаар бага хэмжээгээр тээвэрлэж, хадгалж авч явсан бол хэргийг хэрхэн зүйлчлэх эсэх нь эргэлзээтэй байна. Ийм нөхцөлд мансууруулах бодис тээвэрлэж явсан этгээдийн санаа зорилго, тээврийн хэрэгсэл ашигласан зорилго, тээвэрлэж явсан мансууруулах бодисын хэмжээ, уг бодисыг хаана хадгалж авч явсан зэрэг хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй.

Нөгөө талаар “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар онц их хэмжээтэй олж авсан, хадгалсан этгээд уг эд зүйлийг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар онц их хэмжээтэй тээвэрлэсэн, илгээсэн тохиолдолд хэргийг нийлмэл гэмт хэрэг гэж үзэн Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-д зааснаар, эсвэл 192.3.1-д зааснаар зүйлчлэх эсэх нь маргаантай байна.

7. “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар “бэлтгэсэн” гэдэгт ямар үйлдлийг хамааруулан ойлгох вэ гэдэгт анхаарах шаардлагатай.

Мансууруулах үйлчилгээтэй ургамал, эмийн, химийн бодис болон бусад түүхий эдээс нэг буюу хэд хэдэн ширхэг мансууруулах бодис, бэлдмэлийг гар болон үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, мөн мансууруулах бодисын агууламжийг нэмэгдүүлэх, мансууруулах үйлчилгээтэй бодисыг ялгаж авах, хэрэглэхэд хялбар болгох зорилгоор түүхий эдийг дахин боловсруулсан санаатай үйлдлийг “бэлтгэсэн” гэдэгт хамааруулан ойлгох бөгөөд мансууруулах үйлчилгээтэй бэлдмэл, бодис бэлтгэх үйлдлийг хийж эхэлснээр уг хэргийг төгссөнд тооцох нь зүйтэй.

Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж үзэхэд шүүгдэгч нар нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс түүж цуглуулсан мансууруулах үйлчилгээтэй өвсийг нүдэж, бэлдмэл бэлдсэн, түүнийгээ өөрсдөө тамхинд хийж татах, шатааж утааг үнэртэх зэргээр хэрэглэх, мөн бусдад дамжуулсан, худалдсан талаар мэдүүлжээ.

Тухайлбал, *Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008 онд хянан шийдвэрлэсэн хэргийн 33 тоот шийтгэх тогтоолд дурьдсанаар нэр бүхий шүүгдэгч нарын Төв аймгийн нутагт ургадаг “Намир цэцэг” гэх ургамлаас гаргаж авсан гэх бэлдмэл нь НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц-ийн хавсралтын 1 дүгээр жагсаалт, 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын тухай конвенцийн хавсралтын 2 дугаар жагсаалт, “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 196 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 139/А/148 тоот тушаалаар батлагдсан “Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт”-ын хавсралт, мөн Эрүүл мэндийн сайдын 2003 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 306 тоот*

тушаалаар батлагдсан “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг нийлүүлэх, үйлдвэрлэх, хэрэг журам”-ын 4 дүгээр хавсралтад заасан “Зэрлэг олс” /*Cannabis ruderalis*/ хэмээх ботаникийн монгол нэршилтэй ургамлаас гаргаж авсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт үйлчилгээ бүхий C21H3002 химийн томьёотой “тетра гидро каннабинол, дельта 9” хэмээх бодис болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон байна.

Мөн Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008 онд хянан шийдвэрлэсэн хэргийн 296 тоот шийтгэх тогтоолд дурдсанаар шүүгдэгчийн Дархан-Уул аймгийн нутагт ургадаг ургамлыг түүж хэрэглэхэд бэлдсэн бэлдмэлээс мансууруулах бодисны талаар НҮБ-аас болон Монгол Улсын Засгийн газраас баталсан “Мансууруулах бодисын жагсаалт”-д орсон “Норметадон” гэх мансууруулах бодис илэрсэн нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогджээ.

8. Эрүүгийн хуулийн 192.2-т заасан мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “тээвэрлэсэн” гэдэгт бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг нэг газраас нөгөө газарт хууль бусаар тээвэрлэсэн санаатай үйлдэл хамаарах боловч дээрх эд зүйлийг явганаар зөөвөрлөсөн үйлдлийг “тээвэрлэсэн” гэх хүндрүүлсэн нөхцөлд хамааруулахгүй.

Харин Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хадгалсан гэх үйлдлийг “тээвэрлэсэн” гэх үйлдлээс ялгаж зүйлчлэх явдал практикт маргаан дагуулж болохоор байна. Иймд хуульчид дээрх асуудлыг шийдвэрлэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан эсэх, нэг удаагийн хэрэглээнээс хэтэрсэн хэмжээний мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг зөөвөрлөсөн эсэх, мөн мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эзлэх хэмжээ, түүнийг нуун далдалсан байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй. Иймд, нэг удаа, өөрөө хэрэглэх зорилгоор мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бага хэмжээгээр зөөвөрлөсөн үйлдлийг “тээвэрлэсэн” гэх үйлдэлд хамааруулж, хэргийг хүндрүүлэн зүйлчлэх шаардлагагүй гэж үзэж байна.

9. Эрүүгийн хуулийн 192.2-т заасан мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “борлуулсан” гэдэгт бусдад хариу төлбөртэй болон төлбөргүйгээр шилжүүлсэн бүх үйлдлүүдийг хамааруулан ойлгох нь зүйтэй. Тухайлбал, худалдах, бэлэглэх, солилцох, төлбөрт тооцож өгөх, зээлээр өгөх гэх мэт. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бусдад шилжүүлсэн арга, мөн түүний хэмжээ зэрэг нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, мансууруулах үйлчилгээтэй гэж итгүүлэн борлуулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэргээр зүйлчилнэ.

Харин мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис гэж гэмт этгээд өөрөө итгэн түүнийгээ бусдад борлуулсан боловч тухайн бодист мансууруулах үйлчилгээ байхгүй байсан бол мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “борлуулахаар завдсан” гэж үзэн хэргийг зүйлчилнэ. Улмаар худалдан авагчийг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар олж авахаар завдсан гэж үзнэ. Энэ тохиолдолд мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар олж авсан этгээд ямар зорилгоор /өөрөө хэрэглэх, бусдад дамжуулах гэх мэт/ дээрх эд зүйлийг авсан нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

10. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтох нь хэрэглэгчийн хувьд өвчин эмгэг, нөгөө талаар нийгмийн аюул ихтэй энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд цаг алдахгүй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үүднээс энэ хэргийг үйлдэгч нь гэмт хэргээ сайн дураар илчилж, өөрт байсан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хуулийн байгууллагад хураалгаж, гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн бусад этгээдийг илрүүлэхэд идэвхитэй дэмжлэг үзүүлсэн бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх заалтыг нэмж оруулах нь зүйтэй.

11. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл

зохион байгуулалттайгаар, нууц далд аргаар үйлддэг онцлогтой тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдтэй хууль сахиулах байгууллагууд хамтарч ажиллах нь илүү үр дүнтэй.

Гэтэл энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, шүүн таслах ажиллагаанд саад учруулж, гэмт хэргийг нуун далдалсан үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцоогүй тул тухайн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

Зөвхөн Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйл “Хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх” гэмт хэргийг нуун далдалсан тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Иймд Эрүүгийн хуулийн 247-р зүйлд Эрүүгийн хуулийн 192-196-р зүйлд заасан гэмт хэргүүдийг урьдчилан амлалгүйгээр нуун дарагдуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

IV. ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах явдал жил ирэх тусам өссөн нь геополитик, нийгэм, эдийн засгийн байдал, хөгжил, дэд бүтэц, хяналт шалгалт, эрх зүйн орчин, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар, сэтгэхүй, төлөвшил, гадаад орны зарим иргэдийн сөрөг нөлөөллөөс шалтгаалж байна.

Түүнчлэн зарим аймгийн нутаг дэвсгэрт мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлийн гаралтай ургамлын тархац, уг бодисын хамааралтай иргэд, гадаадын иргэд, амар хялбар аргаар мөнгө олж амьдрах хүсэл эрмэлзлэл, шунал давамгайлсан, хувь хүний ухамсар, ёс суртахуун, энэ төрлийн гэмт хэрэг, түүний хор уршгийн талаарх ойлголт хангалтгүй, өсвөр насны хүүхдүүд “бухимдлаа тайлах”, “дууриах”, “нөлөөнд автах” зэргээр энэ төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож байна.

Сүүлийн үед лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хэрэглэж байгаагаас үзэхэд уг бодисын нэр төрөл олширч, үйлчилгээ хурдан мансууруулах төрлийн бодис хэрэглэдэг, хэрэглэгчийн давхарга бий болж, донтогчдын нас залуужин хэрэглэгч, зуучлагч, тээвэрлэгч хэдийнээ бий болжээ.

Монгол Улсын хэмжээнд өсвөр үе, залуучуудын архи, тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус хэрэглээ нь хэвлэл, мэдээллийн чөлөөт байдал, интернэтийн дэвшилтэт техник, технологи нэвтэрсэнтэй холбоотой бөгөөд үндэсний аюулгүй байдлын хэмжээнд аюул заналхийллыг хэдийнээ бий болгожээ.

Монгол Улсад одоогийн байдлаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь бүх нийтийн нөхөн үржихүйн хүрээ, бие махбодь болон сэтгэцэд бодитоор нөлөөлөхүйц нийгмийн сөрөг үзэгдлүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзлэхгүй байгаа хэдий ч олон жилийн турш мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй ч энэ гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд богино хугацаанд эрчимтэй өссөөр байна.

Тухайн гэмт хэргийн тоо жил ирэх тусам өсч, түүнийгээ дагаад гэмт хэрэгт холбогдогч этгээдүүдийн тоо өсч байгаа нь Монгол Улсын хүн амын дунд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдсэн.

“Мансууруулах бодистой тэмцэх үндэсний хөтөлбөр” 2000-2005 оны хооронд Монгол Улсад мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах бодист донтох шалтгаан ба үүслийг тодорхойлох, хууль ёсны хүрээнд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг арга хэмжээ авах хөтөлбөр боловсруулсан хэдий ч хөтөлбөрийг цааш нь хэрэгжүүлээгүй зогсоосон байна. 2005 оноос өнөөдрийг хүртэл дахин хар тамхи мансууруулах бодистой тэмцэх нэгдсэн бодлого, хөтөлбөр манай улсын хэмжээнд боловсрогдоогүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг өсөж, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо огцом өсөх хандлагатай байна.

2002 онд батлагдаж, 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль нь зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хууль ёсны эргэлтийг зохицуулсан хууль болсон тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан тусгайлсан хуультай болох шаардлагатай. Мөн уг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт Мэргэжлийн хяналтын байгууллага, Гаалийн болон хил, хяналтын байгууллага, Цагдаа, тагнуулын болон холбогдох бусад байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэгтэй бөгөөд уг байгууллагуудын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул “Үндэсний хороо орон тооны ажлын алба”-тай байна гэж заасан боловч дээрх заалтыг хэрэгжүүлж өнөөдрийг хүртэл энэ хороог байгуулаагүйгээс гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн бодлогогүй явсаар өдийг хүрсэн.

Манай хойд хөрш ОХУ-д 18 сая хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч байна гэсэн судалгаа байдаг бол үүнээс жилд **500,000** донтогч сайн дураараа мэргэжлийн эмнэлгийн байгууллагад хандаж, 50,000 нь эмчилгээгээ бүрэн хийлгэдэг. Харин хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч дундаас 1 жилд 70,000 хүн буюу 1 өдөрт дунджаар 192 хүн нас бардаг гэсэн судалгаа байдаг.

Харин манай урд хөрш БНХАУ-д **2 345 000** хүн хар тамхи, мансууруулах бодисын хамааралтай болсон гэж албан ёсны бүртгэлтэй жилд дунджаар 243,000 мансуурагч, донтогч нэмэгддэг гэсэн тоо баримт байдаг байна. Бүртгэгдсэн донтогч нарын 1,465,000 нь 35-аас доош насны, 870,000 нь 36-59 насны, 11,000 нь 60-аас дээш насныхан гэсэн судалгаа байдаг бөгөөд тэдний эрчүүд нь эмэгтэйчүүдээсээ 6 дахин их гэсэн тоон үзүүлэлт байна. Мөн судалгаагаар 18 нас хүрээгүй бага насны 43,000 хэрэглэгч 2014 онд бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 25,000 хэрэглэгчээр илүү бүртгэгдсэн байна. Тэдний дундаас хамгийн бага нь 11 настай хүүхэд байсан байгаа зэрэг судалгаанаас үзэхэд манай улсад хар тамхины аюул маш ойрхон аюулын харанга дэлдэж байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд улсын хэмжээнд бүртгэгдсэн статистик мэдээнд тулгуурлан, мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг цагдаагийн мэргэжлийн албаны мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээлээ.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвөөс эрхлэн гаргасан статистик мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ:

2006-2016 онд улсын хэмжээнд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой нийт 356 гэмт хэрэг үйлдэгдсэний **82.1** хувь нь нийслэлд бүртгэгджээ. /Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн **0.2** хувийг эзэлдэг байна/ Жилд дунджаар 32, сард 2.7 гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, холбогдогч



Монгол Улсад сүүлийн 11 жилийн хугацаанд энэхүү гэмт хэрэгтэй холбоотой 414 холбогдогчтой 356 гэмт хэрэг бүртгэгдэж¹¹, цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг 2015 онд улсын хэмжээнд 73 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 15 хэргээр буюу 25.9 хувиар, үүнээс Улаанбаатар хотын хэмжээнд 63 бүртгэгдсэн нь 10 хэргээр буюу 18.9 хувиар тус тус өссөн байна.

ЭХТА 192 дугаар зүйл буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг 71 буюу 97.3 хувийг, ЭХТА 193 дугаар зүйл буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих гэмт хэрэг 2 буюу 2.7 хувийг тус тус эзэлж байна¹².

Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:


Газар нутаг	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Эзлэх хувь	
	2014	2015		2014	2015
Баян-Өлгий		1			1.4
Ховд		1			1.4
Булган		1			1.4
Орхон		1			1.4
Говьсүмбэр	1			1.7	
Дархан-Уул		2			2.7
Дорноговь	1	1	0.0	1.7	1.4
Өмнөговь	1			1.7	
Сэлэнгэ	2	1	-50.0	3.4	1.4
Төв		2			2.7
Баянгол	11	13	18.2	19.0	17.8
Баянзүрх	11	19	72.7	19.0	26.0
Сүхбаатар дүүрэг	12	7	-41.7	20.7	9.6
Сонгинохайрхан	6	6	0.0	10.3	8.2
Хан-Уул	5	4	-20.0	8.6	5.5
Чингэлтэй	7	12	71.4	12.1	16.4
Багануур	1	2	2.0 дахин	1.7	2.7

¹¹ ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төвийн статистикийн мэдээллээр

¹² Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвөөс эрхлэн гаргасан “Монгол Улс дахь 2015 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал”, 2016

2015 онд нийт 143 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 буюу 14.4 хувиар өссөн байна. Үүнээс 27 буюу 18.9 хувь нь эмэгтэй, 116 буюу 81.9 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 8.0 хувиар, эрэгтэй 16.0 хувиар тус тус өссөн байна.

Нас, нийгмийн байдал:




Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 10.5 сая төгрөгийн хохирлын 1.9 хувийг нөхөн төлүүлж, 11.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.


2016 оны эхний 9 сарын байдлаар Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг 63 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 21 хэргээр буюу 33.3 хувиар, үүнээс Улаанбаатар хотын хэмжээнд 56 бүртгэгдсэн нь 22 хэргээр буюу 39.3 хувиар тус тус өссөн байна. Эдгээр гэмт хэргийн 56 нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн газрын холбогдох албаны мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ:

Манай улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой хэрэг 2002 онд 5 хүн 2 хэрэгт холбогдон шалгагдсан статистик үзүүлэлтээс 2016 оны эхний хагас жилд **120 хүн 147 үйлдэлтэй 52** хэрэгт холбогдон шалгагдах хүртэл жил бүр дунджаар 9 хэрэг, 35 хүнээр өссөөр байгааг бүртгэгдсэн гэмт хэргийн статистик¹³ мэдээллээс харж болно.




¹³ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсээс 2002-2016 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан статистик мэдээ



Сүүлийн 3 жил буюу 2013-2015 онуудад цагдаагийн байгууллагад шалгагдсан энэ төрлийн гэмт хэрэг болон сэжигтэн, яллагдагчийн тоо ч өссөн үзүүлэлттэй байна.

Хураагдсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис 2014 онд нийт дүнгээрээ 13997 грамм байсан бол 2015 онд 10177 байгаа нь буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа ч чанарын хувьд өссөн үзүүлэлттэй байгааг дараах байдлаар тайлбарлаж болно.

Синтетик буюу хүчтэй үйлчилгээтэй сэтгэцэд нөлөөтэй бодис болох метамфетаминь төрлийн мөс хэмээх бодис 2014 онд 141 грамм хураагдаж байсан бол 2015 онд 344.1 грамм, 2014 онд боловсруулсан зэрлэг олс буюу Гашиш 15 грамм хураагдаж байсан бол 2015 онд 24.5 грамм хураагдсан зэрэг чанарын хувьд нэмэгдсэн.



Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгт 2010 оноос хойш ял шийтгэгдсэн 49 ялтан байгаа бөгөөд эдгээрийн 59 хувь буюу 29 ялтан 5-аас доош жил 6 сараас 3.6 жил хүртлэх (3.5 жилээр хорих ял шийтгэгдсэн 1, 3.6 жилээр хорих ял шийтгэгдсэн 1) хугацаагаар хорих ял шийтгэгдсэн ялтанууд байна. Үүнээс гадна одоогийн байдлаар Эрүүгийн цагдаагийн газарт хар тамхины хэрэгээр шалгагдаж буй 35 сэжигтэнүүд бүгд хууль бусаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис олж авсан, хадгалсан, хэрэглэсэн хүмүүс, өөрөөр хэлбэл хөнгөн буюу хүндэвтэр хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан болсон, хүнд болон онц хүнд гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, үндэсний болон олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээг хянах, төрийн мониторингийг нэвтрүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Хүүхэд залуучуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын талаарх үнэн бодит мэдээллийг хүртээмжтэй түгээх. Үүний тулд хууль сахиулах байгууллага болон хамтран ажиллагч бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын хүчин чармайлт чухал бөгөөд мансууралтай тэмцэх нь юуны өмнө цагдаагийн байгууллагын дангаараа хүлээх үүрэг биш гэдэг хандлагыг төлөвшүүлэх ёстой. Төрөөс залуучууд, хүүхдүүдийн чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, тэдэнд амьдарлын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх талаар хичээлээс гадуурх дугуйлан, секцүүд бий болгох, авьяас чадварыг хөгжүүлэх аливаа сургалт семинар зохион байгуулах, халамжлан хүмүүжүүлэх хөтөлбөр, зуны цагт ажил хөдөлмөр эрхлэх явдлыг дэмжих чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.


Хууль сахиулах байгууллагын хүч хэрэгсэллийг тухайн гэмт явдлын үндсэн шалтгаан болсон хүн, байгууллага, үйл явдалд чиглүүлж ажиллуулах шаардлагатай. Нийгмийн хор аюулаар харьцангуй багатай, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар олж авсан хэрэглэсэн хүмүүсийг мөрдөн шалгах нь хууль сахиулах

байгууллагуудын хувьд цаг хугацаа алдаж, шоронд ял эдлэгсдийн тоог нэмэгдүүлэхээс өөр тустай зүйлгүй байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай.

Олон улсын хар тамхины эргэлтийг хянах, төрийн мониторингийг нэвтрүүлэх ажилд иргэний байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих явдал чухал бөгөөд дотоодын эрэлтийг багасгах замаар гадаадаас нийлүүлэгдэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын урсгалыг хязгаарлах боломжтой. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх шаардлагатай гэжээ.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байдал¹⁴:

Монгол Улсын шүүхээр 2010 оноос хойш **267** хүн хар тамхитай холбоотой хэргээр ял шийтгүүлсэн. 2016 оны эхний хагас жилийн байдлаар **54 хүнд холбогдох 32 эрүүгийн хэргийг** шийдвэрлэсэн. Ял шийтгүүлсэн хүмүүсийн дийлэнх нь буюу 75.9 хувь нь 18-29 насныхан байна.



2007 онд анх Монгол Улсын иргэн хар тамхи тээвэрлэсэн хэргээр ял авч байсан. БНХАУ-д 50 граммаас дээш хэмжээгээр Героин тээвэрлэж явбал ялын дээд хэмжээ авдаг. Монгол Улсын **33** иргэн хар тамхины хэргээр хилийн чанадад ял эдэлж байна. 2016 он гарснаас хойш 11 иргэн хар тамхи зөөвөрлөсөн хэрэгт холбогдсон.

Монгол Улсын хилээр жилд дунджаар 1,6 сая автомашин, 1 сая гаруй ачааны болон суудлын вагон, 6500 агаарын хөлөг нэвтэрдэг гэсэн статистик тоо баримтыг гаргасан байдаг. Шалган нэвтрүүлэх алба 2014 онд Гадаадын иргэн, харьяатын байгууллагад шилжсэнээр дээр дурьдагдсан олон сая тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалтыг хийх боломж үгүй болсон нь энэхүү гэмт хэргийн тоо өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна. Учир нь шалган нэвтрүүлэх албыг гадаадын иргэн, харьяатын албанд шилжүүлснээр 24 цагийн турш улсын хил хамгаалалт, хилийн манааны үүрэг гүйцэтгэх ажиллагаа суларсныг ашиглан богино хугацаанд их ашиг олох зорилгоор залуучууд хар тамхи тээвэрлэх, хэрэглэх нь ихсэж байгаа нь дараах судалгаанаас харагдана.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг

Он	Хар тамхи, мансууруулах бодис худалдсан,
----	--

¹⁴ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээллээр

	борлуулсан, хадгалсан гэмт хэрэг
2013	36 хэрэгт 96 хүн
2014	61 хэрэгт 153 хүн
2015	79 хэрэгт 169 хүн
2016 он Эхний 6 сарын байдлаар	43 хэрэгт 130 хүн

Дээрх судалгаанаас үзэхэд хар тамхи, мансууруулах бодисын наймааны хүрээ улам бүр өргөжиж, Монгол Улс энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгч, хэрэглэгч орон болсныг харуулж байна. 2016 оны байдлаар манай улсын 33 иргэн хар тамхитай холбоотой гэмт хэргээр гадны улсын шоронд хоригдож байна. Гэмт хэрэгт холбогдсон 1 хүний ард 10 хүн байх магадлалтай гэж үзэхэд манай улсад ойролцоогоор 2000 гаруй хүн энэ төрлийн бодисыг хэрэглэдэг тоо баримт байна. Улаанбаатар хотод хоногт дундажаар 10 сая төгрөгийн мансууруулах бодис худалдаалдаг гэсэн мөрдөн байцаагчийн мэдэгдэл гарсан.¹⁵

¹⁵ www.sonin.mn.2016.08.04

V. ШАЛТГААН НӨХЦӨЛ, ХҮЧИН ЗҮЙЛ

Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг 3 хэсэгт авч үзэж байна. Үүнд:

Манай улсад ургаж байгаа мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархац их байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийн 50-60 хувийг мансууруулах үйлчилгээтэй ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байна.

Зүүн өмнөд Азийн улс орнууд болон хил залгаа БНХАУ-аас Монгол Улсын хилээр хууль бусаар сентитик төрлийн мансууруулах бодис болох амфетамин, метамфетамин, нэвтрүүлэх, зарж борлуулах, хэрэглэх үйлдэл нэмэгдсээр байна. Мөн Олон Улсын шуудан илгээмжийн үйлчилгээг ашиглан Хар тамхи, мансууруулах бодисыг Монгол Улсад нэвтрүүлэн худалдах, хэрэглэх нь нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсад хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, хөтөлбөр, хууль эрх зүйн орчин муу байгаа зэрэг нь нөлөөлж байна.

Хөрш улсуудын хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдийн тоон үзүүлэлт болон манай улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлд нэгдсэн үнэлэлт дүгнэлт өгөхөд манай улс хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх асуудлыг Төрийн нэгдсэн бодлоготойгоор, байгууллагын уялдаа холбоог зангидан хамтран хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Дэлхийн хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдлын талаар жил бүр зохион байгуулагддаг Олон улсын хурлыг 2016 оны 04 дүгээр сарын 24-30-ны өдрүүдэд АНУ-ын Хар тамхитай тэмцэх алба, Бүгд Найрамдах Перу Улсын Үндэсний цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан бөгөөд энэ удаа “Үндэстэн дамнасан хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаахтай тэмцэх асуудал нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох нь” сэдвээр ээлжит 33 дугаар хурал болж өнгөрсөн. Уг хуралд дэлхийн 127 орны цагдаагийн болон хар тамхитай тэмцэх албаны 535 алба хаагч өөрсдийн орныг төлөөлөн оролцож өөрийн орны хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, хар тамхи тариалагч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, тээвэрлэгч гэмт бүлэглэл, синдикат, картелуудтай хийж буй тэмцэл, үр дүн, 2016-2017 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хувьсал өөрчлөлт, шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын талаар мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагааны туршлага солилцох зэрэг боломж олгосон уулзалт арга хэмжээг зохион байгуулж олон улсад хар тамхитай тэмцэх чиглэлээр үүрэг гүйцэтгэдэг албадын хамтын ажиллагааг бэхжүүлсэн хурал болсон байна. Хурлын тайланд дурдагдаж буйгаар 2015-2016 оны тайлант хугацаанд дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж буй хар тамхитай тэмцэх албад нь Өмнөд Америкийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй гэмт бүлэглэлд 5 удаагийн томоохон цохилт өгч 69 тонн кокаин, 80 орчим тонн каннабисын ургамалыг хураасан, Европ, Африк, Хойд Америк, Азийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэлүүдэд мөн давхардсан тоогоор 30 орчим цохилт өгөх арга хэмжээ зохион байгуулж үр дүнтэй ажилласан байна. Монгол Улсын талаар хийсэн үнэлгээнд героин, амфетамин, каннабис, экстазийн төрлийн мансууруулах бодисын хэрэглээ өсөлттэй, тархацын хувьд каннабис хамгийн их, намуугийн тархалттай, экстазийн үрсгал БНХАУ-аас чиглэсэн, героин, амфетамин төрлийн бодисын худалдааны замууд дайран өнгөрч байна гэж дүгнэгдсэн байна.

Манай улсын хар тамхи, мансууруулах бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт, хэрэглэгч нарын тоо бусад дэлхийн улс орныхтой харьцуулахад бага, их хэмжээгээр зөрүүтэй харагдаж байгаа хэдий ч улсын хүн амын тоо, хөрш залгаа улс орнуудын хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчийн тоо, тэдэнтэй тэмцэх аргачлал зэргийг харьцуулахад өнөөдрийн байдлаар манай улсад уг цагаан тахал гэгч зүйл хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд аюул авчрахуйц нөхцөл байдал үүссэн байна.

Монгол Улсад сүүлийн 3 жилд бүртгэгдсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоон мэдээг авч үзвэл: Өнөөдөр Монгол Улсад хар тамхи,

мансууруулах бодис байнга хэрэглэдэг хэрэглэгчид бий болж, хууль бус эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ өсөн нэмэгдсэн, төрөл зүйл нь олширсон, ашиг орлогын үндсэн эх үүсвэр болгох зорилгоор олж авах, зарж борлуулах зэрэг гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч байгааг үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээнээс харж болно.

- ✓ 2002-2006 оны хооронд дунджаар **1 жилд 8 гэмт хэрэгт 21 хүн**,
- ✓ 2007-2011 оны хооронд дунджаар 1 жилд 14 гэмт хэрэгт 50 хүн,
- ✓ 2012-2016 оны 6 сарын 24-ны өдрийн байдлаар дунджаар **1 жилд 46 гэмт хэрэгт 135 хүн шалгагдсан байгаа** нь сүүлийн жилүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 2002-2006, 2007-2011 оны хооронд бүртгэгдсэн гэмт хэргийн дундажтай харьцуулахад:
 - ✓ 2002-2006 оны дундажтай харьцуулахад гэмт хэрэг 5.8, холбогдогч 6.5 дахин,
 - ✓ 2007-2011 оны дундажтай харьцуулахад гэмт хэрэг 3.3, холбогдогч 2.7 дахин тус тус өссөн үзүүлэлт харагдаж байна.
 - ✓ 2016 оны 06 дугаар 24-ны өдрийн байдлаар 97 хүнд холбогдох 40 гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 19 гэмт хэргээр буюу 75 хувиар, холбогдогч 37 хүнээр буюу 61.6 хувиар тус тус өссөн байна.

Цагдаагийн байгууллагын бүтцээр хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэн Хар тамхитай тэмцэх хэлтэс үүсгэн байгуулсан ч уг төрлийн гэмт хэргийн тоо, түүнийгээ дагаад гэмт хэрэгт холбогдох этгээдүүдийн тоо жил ирэх тусам өсөж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад арга хэрэгсэл, хөтөлбөрийг ашиглах шаардлагатай байгааг харуулж байна.

Дээрх тоон үзүүлэлт, судалгаанаас үзэхэд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдсан насанд хүрээгүй этгээдүүдийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа тул хар тамхины хор хөнөөл болон хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, боловсролын байгууллагуудтай хамтран зохион байгуулвал дээрх төрлийн гэмт хэргийн гаралт буурах хандлагатай байна.

Үүнээс гадна насанд хүрээгүй этгээдүүдийн интернет орчинд чөлөөтэй хандах эрх, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг сурталчилсан мэт мэдээ мэдээлэл, дуу клип, кино зэрэг бодит асуудалд анхаарал тавих цаг болсон байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын 40.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 76.3 хувь нь 18-35 насны залуучууд байна. Үүнд:

- Ажилгүй гэдэгт ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэггүй, амьжиргааны түвшнөөс доогуур орлоготой иргэд бус харин амьдрал, мөнгөний эх үүсвэр нь хувийн бизнес эсвэл эцэг, эхийн мөнгө, хөрөнгөөр хар тамхи мансууруулах бодисын хэрэглээг авдаг этгээдүүд дийлэнх нь байна.

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч 18-35 насны залуучууд нь ихэвчлэн гэр бүлтэй, тогтсон амьдралтай байдаг ба хар тамхи, мансууруулах бодис нийлүүлж, борлуулж байгаа этгээдүүд нь тэднээс цөөн тооны байдаг учир хэрэглэгч, худалдан авагч нарын дунд найз нөхдийн харилцаа холбоо үүсдэг байна.

2013-2015 оны хооронд дээрх төрлийн гэмт хэрэгт шалгагдсан этгээдүүдийг харилцаа холбоогоор нь авч үзвэл эхнэр нөхрийн харилцаатай 4, зүс мэдэх 44, найз нөхөд 235, урьд гэмт хэрэг хамтран үйлдэж байсан 2, огт танихгүй 20 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан төрийн алба хаагч нараас эрүүл мэндийн байгууллагын ажилтан 2, хуулийн байгууллагын ажилтан 2 хүн байна.

Гэмт хэргийн холбогдогч нарыг нас, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар ангилахад сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүүхэд, оюутан залуучууд хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох тохиолдол ихэссэн тул дунд сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутан залуучууд дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү явуулах шаардлагатай байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийг хүйсийн байдлаар авч үзвэл 2013, 2014, 2015, 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан насанд хүрээгүй хүмүүс дунд эмэгтэй хүүхэд бүртгэгдээгүй байна.

Дээрх төрлийн гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүс нь хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээллийг интернет, цахим хуудас, кино болон найз нөхдөөсөө олж авсан байна. Түүнчлэн хүүхдүүдийн ар гэр тогтворгүй, анхаарал халамж сул, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар хомс, хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, суурь хүмүүжил, ухамсар зэрэг нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байна. Судалгаанаас үзэхэд, 2013, 2014 онд хар тамхи, мансууруулах бодисыг ихэвчлэн сургалтын төлбөр өндөр, улсын тэргүүний гэх тодотголтой сургуулийн сурагч нар хэрэглэдэг байсан бол 2015 оны судалгаанаас харахад нийгмийн давхарга харгалзахгүйгээр уг гэмт хэрэгт холбогддог болсон байна.

Иймд насанд хүрээгүй хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор дараах арга хэмжээг авах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Өрхийн орлого бага, өрх толгойлсон эцэг, эхтэйгээ амьдардаг, зан төрхийн өөрчлөлттэй мэтийн гэмт хэрэгт холбогдож болзошгүй эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгаануудыг бүхий л шатанд гаргаж байх.

- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүүхдүүдийг хүүхдийн байгууллага болон харъяалагдах засаг захиргааны нийгмийн ажилтан анхааралдаа авч, бусад байгууллагуудтай хамтран хүүхдүүдэд зориулан хувь хүний хөгжил, төлөвшил, амьдрах ухааны сургалтууд, олон нийтийн янз бүрийн арга хэмжээнүүдийг байнга авч явуулж хэвших. Үүнд, хүүхдүүдэд сэтгэл зүй, харилцаа, зөрчлийг шийдвэрлэх чадварыг сайжруулах практик сургалтууд явуулж байх.

- Хүүхдүүд хууль эрх зүйн мэдлэггүйгээс болж гэмт хэрэгт холбогдож байгаа учраас тэдэнд хууль эрх зүйн мэдлэг олгохын тулд бүх шатны сургуулиуд болон хүүхдүүд олноор цугладаг газруудад (РС тоглоомын газруудад гэх мэт) янз бүрийн таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг сонирхолтой хэлбэрүүдээр авч явуулах шаардлагатай. Хүүхдүүд чөлөөт цагаа сонирхолтой, үр бүтээлтэй өнгөрөөхөд зориулсан газруудын тоо болон тэнд хамрагдах хамрагдалтыг нэмэгдүүлэх.

- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд стресс, сэтгэл түгшилттэй байгаа учраас сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл засал эмчилгээнд хамруулах

- Бүх шатны сургуулиудын сурагчдад, ялангуяа гэмт хэрэг үйлдэж болзошгүй, эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд зориулан сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл засал эмчилгээ хийдэг мэргэшсэн сэтгэл зүйчдийг бэлтгэж ажиллуулах.

- Сургуулийн нийгмийн ажилтнууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах, хүүхдүүдэд хар тамхины хор хөнөөл, учрах үр дагаврыг таниулж ойлгуулах, хүүхэд тус бүртэй тулж ажилладаг байхад анхаарах

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөнөөс үүдэлтэй сүүлийн үед интернет цахим хуудсууд болон сонин, сэтгүүл, телевиз, радиогоор хар тамхи мансууруулах бодисын талаар хэт дэлгэрэнгүй, сурталчлах өнгө аястай мэдээ мэдээлэл гарч байгаа нь өсвөр насны хүүхдүүд эсрэгээр ойлгох, сонирхох сэтгэгдэл төрүүлж тэднийг гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа учир хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт, хэмжүүр тогтоох.

Гэмт хэргийн өсөлт болон амьдрал, гэр бүлийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан уг төрлийн гэмт хэрэгт холбогдсон эмэгтэй хүний тоо өсөж байна. Гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүд нь хар тамхи, мансууруулах бодис зарж, борлуулдаг этгээдүүдтэй байнгын харилцаа холбоотой байдаг ба ихэвчлэн гэмт хэрэгт хар тамхи, мансууруулах бодисын хэрэглэгч, зуучлагч хэлбэрээр холбогдож байна.

Улсын хэмжээнд

- ✓ 2013 онд: 4979,9 грамм каннабис, 198,8 грамм гашиш, 61,7 грамм мөс,
- ✓ 2014 онд: 13841 грамм каннабис, 15,5 грамм гашиш, 140,74 грамм мөс,
- ✓ 2015 онд 9808,21 грамм каннабис, 24,51 грамм гашиш, 344,164 грамм мөс,
- ✓ 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 658,72 грамм каннабис, 86,9 грамм гашиш, 0,4 грамм Кокаин, 285,44 грамм мөс тус тус хураагдсан байна.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад онц хүнд гэмт хэрэг болон “мөс”-тэй холбоотой гэмт хэргийн тоо ихээр өссөн. Мөс гэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бусдад давтан үйлдлээр зарж борлуулах гэмт хэргийн гаралт өссөөр байна. Мөн сүүлийн жилүүдэд 2013 онд Монгол Улс эмчилгээнд хэрэглэх эмийн жагсаалтаас хассан, 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Эрүүл мэнд, спортын яамны сайдын 68 дугаартай

тушаалаар хяналтад авсан сэтгэцэд нөлөөт Залеплон гэх бодис агуулсан “Анданте” гэх эмийг дунд сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутан залуучууд хэрэглэж донтох өвчнөөр өвчлөх болсон. Анданте гэх эм нь Оросын Холбооны улсад худалдаалагддаг тул хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг 2015 онд 1, 2016 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 2 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон манай улсын иргэдийг энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс ихэвчлэн интернет сайтуудаар /wechat, yahoo, facebook, tagged.com/ танилцан судлах, тэдний Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэ итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох зэрэг сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэд татан оруулж тээвэрлэлт хийлгэн БНХАУ-аас мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис олж авч, хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлж тээвэрлэсэн гэмт хэргийн тоо өссөн байна. Үүнд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг бол тухайн улсын их, дээд сургуульд суралцаж төгссөн, олон жил ажил хөдөлмөр эрхэлсэн эсвэл тухайн улсад биеэ үнэлж байсан этгээдүүд хар тамхи борлуулагч этгээдүүдтэй хань харилцаатай болж мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийн захиалагч, гүйцэтгэгч болж байгаа явдал юм.

Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоо байхгүй байна.

Үндэсний хөтөлбөрийг урт буюу 10-20 жилийн хугацаатайгаар батлуулж хэрэгжүүлэх.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтох нь хэрэглэгчийн хувьд өвчин эмгэг, нөгөө талаар нийгмийн аюул ихтэй энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд цаг алдахгүй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үүднээс энэ хэргийг үйлдэгч нь гэмт хэргээ сайн дураар илчилж, өөрт байсан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хуулийн байгууллагад хураалгаж, гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн бусад этгээдийг илрүүлэхэд идэвхитэй дэмжлэг үзүүлсэн бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх заалтыг нэмж оруулах нь зүйтэй.

Монгол Улсад түр оршин суугаа болон цагаач иргэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг ихээр хэрэглэдэг учраас хүүхэд, залуучуудыг уруу татах, мөн энэ гэмт хэргийн идэвхтэй худалдан авагч болсноор энэ төрлийн гэмт хэргийн зах зээлийн эрэлтийг бий болгож байна. Мөн манай улсын иргэд олноор зорчиж, сурч ажиллаж, амьдарч, улмаар гэмт хэрэгт холбогдож байгаа БНХАУ-ын Бээжин болон Хонконг, Макао, Эрээн, Хөх хот, Малайзын Куала Лампур, ОХУ-ын Улаан-Үд, Москва, Унгар улсын Будапешт, Солонгос улсын Сөүл, Турк улсын Анкара зэрэг хотуудад Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яаманд илээр ажиллаж гэмт хэрэгт хохирсон болон холбогдон шалгагдаж байгаа өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ижил төстэй байгууллагуудын хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн атташе томилон ажиллуулах шаардлага ч харагдаж байгаа юм.

Эмийн сан, эм ханган нийлүүлэх болон эмнэлгийн байгууллагуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт хүчтэй эм, тариа, бэлдмэлийг хараа хяналтгүй зарж борлуулж байгаа явдал нь дээрх төрлийн гэмт хэрэг үйлдэх нэг нөхцлийг бүрдүүлж байна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл болон Монгол Улсын чанарын стандартад бүртгэгдээгүй, баталгаажилт хийгдээгүй эм бэлдмэлийг Монгол Улсын хилээр хууль бусаар оруулж ирэх явдал сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүд, эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудад тавих хараа хяналтыг дан ганц ЭМЯ, УМХГ, Цагдаагийн байгууллагад даатгаад орхих биш гааль, татвар, ХХЕГ зэрэг байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог өргөжүүлж уялдуулах, энэ чиглэлээр төрийн зүгээс цогц бодлого, бодитой арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Интернет, нийгмийн сүлжээнээс хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх төрлийн мэдээ мэдээллийг авч мансууруулагч, донтуулагч ургамал, эм, бэлдмэлийг хэрхэн яаж таних, бэлтгэх талаар зөвлөгөөг олж ашиглаж болохоор байна. Гэтэл манай улс энэ төрлийн ургамал элбэг ургадаг улсуудын нэгийн хувьд энэ төрлийн мэдээ,

мэдээллийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах явдлаас сэргийлэх, хянах техникийн боломжгүй байна.

VI. ДҮГНЭЛТ

- Цагдаагийн байгууллагад 2015 оноос энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх гүйцэтгэх ажил, мөрдөн байцаах нэгж бий болж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, мэдээ мэдээлэл солилцох, нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл ажиллаж байгаа нь үр дүнтэй, ахицтай байгаа хэдий ч Монгол Улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгдсэн бодлогогүй, хар тамхи, мансууруулах бодисын эсрэг нэгдсэн иргэд, холбоо, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо байдаггүй зэрэг нь гэмт хэргийн гаралт буурахгүй, жил ирэх тусам өсөж байгааг харуулж байна.

- Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарын судалгаа нэгдсэн тоо баримт байхгүй нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хаана, хэзээ оновчтой зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө гаргахад хүндрэлтэй. Хүмүүсийг хар тамхи, мансууралд оруулж байгаа гол шалтгааны нэг бол түүний талаар тодорхой мэдлэггүй байх явдал юм. Хар тамхи, мансууруулах бодис муу нөлөөтэй гэдгийг бараг хүн бүр мэддэг боловч чухам ямар их хор нөлөөтэй, аймшигтай үр дагавартайг нь төдийлөн сайн мэддэггүйгээс болж хэрэглэгчдийн тоо өссөөр байна.

- Дүүрэг, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагч нар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мэдлэг, аргачлал дутмаг, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагч, ажилтны орон тоо байдаггүй, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчид өдрөөс өдөрт өөрчлөгдөн шинэчлэгдэж, шинэ хүмүүсээр хүрээгээ тэлж байдаг тул тэдэнтэй бүрэн дүүрэн тэмцэж, нөхцөл байдлыг бүрэн хяналтадаа оруулж чадахгүй байна.

- Монгол Улсад байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг хилийн боомтод хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх техник тоног төхөөрөмж дутагдалтай, хяналт, шалгалт сул, мэргэшсэн ажилтан дутмаг байна.

- Хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын уламжлалт нэр томъёо, түүнд агуулагдах бодисын найрлага молекулын бүтцийг өөрчлөх замаар шинэчлэгдэж, хил, гаалийн байгууллагын ашиглаж байгаа илрүүлэгч техник хэрэгслээр илрүүлэхэд хүндрэлтэй болсон.

- Мансууруулах бодис хууль бусаар хэрэглэгч, донтогчдыг эмчлэх, тэдэнд туслалцаа үзүүлэх, эмчилгээний арга зүй практикт тогтоогүй, стандарт байхгүй, мэргэшсэн эмч ажилтан, наркологийн кабинет, төв дутагдалтай байна.

- Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд одоо Монгол Улс хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай зүй ёсоор гарч байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан тусгайлсан хуультай болох, уг хуулийн хүрээнд “Мансууруулах бодистой тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг шинээр дахин гаргаж төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

- Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийн 50-60 хувийг мансууруулах үйлчилгээтэй каннабисийн төрлийн ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байна. Энэ төрлийн ургамал Монгол Улсын 14 аймгийн 40 гаруй сумын 15.000 орчим га талбайд ургадаг, үрээ цацахаас өмнө (5, 6 дугаар сард) 3 жил дараалан устгавал бүрэн устгах боломжтой гэж мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүд дүгнэдэг тул устгах арга хэмжээг байнга явуулах нь зүйтэй.

- Хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд голлох үүрэг гүйцэтгэдэг гэмт бүлэглэл, синдикатууд /гэмт бүлэглэл/-ын хар тамхийг хүн төрөлхтөнд нийлүүлж буй арга хэрэгсэл боловсронгуй болсон, үйл ажиллагаа нь илүү энгийн бизнесийн зарчмаар явагддаг, гэмт бүлэглэл нь дангаар үйл ажиллагаагаа явуулахаас илүүтэйгээр картел /нэгдсэн монополюуд/-ийн зарчмаар ажиллах болсон.

- Хар тамхитай тэмцэх үүрэг, чиглэл бүхий албад хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, бүлэглэлүүдийг мөрдөн шалгахдаа хураагдсан бодисоос бусад гэмт хэргийн шинжтэй, ялангуяа мөнгө угаахтай холбоотой, хууль бус орлогийг давхар мөрдөн шалгахгүй байгаа гэмт этгээдүүдийн дараа дараагийн хууль бус ажиллагаанд санхүүжилт болж байна.

- Хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгаа нийгмийн эмзэг хэсэгт хангалттай хүрэхгүй байгаа нь эдгээр иргэдийг мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч улмаар хамааралтай болгох, тээвэрлэгч, борлуулагч болгох, гэмт бүлэглэлийн гишүүн болгох зэрэг олон тооны эрсдлийн нэмэгдүүлж байна.

- Олон улсын хамтын ажиллагааг эрхэмлэж хөгжүүлэх өндөр шаардлага бий болсон ялангуяа хөрш орнуудтайгаа гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан хар тамхины гэмт бүлэглэлүүдийн талаарх болон өөрийн оронд албан болон албан бусаар бүртгэгдэж буй шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээллийг солилцож хамтран ажиллах хамтын ажиллагаа хангалтгүй байна.

VIII. САНАЛ

Цаашид энэхүү төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хангах зорилгоор ОХУ болон БНХАУ-ын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичгүүдтэй уялдсан баримт бичгүүдийг боловсруулан баталж, олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;

2. Зохион байгуулалттай, улс дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон энэхүү гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагын бүтэц, тогтолцоог бий болгон урьдчилан сэргийлэх, угтаж илрүүлэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, олон улсын улсын жишиг, туршлага нэвтрүүлэх;

3. Улсын хэмжээнд сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх, хууль бусаар худалдах явдлыг таслан зогсоох зорилгоор эм, бэлдмэл худалдах, үйлчлэх зөвшөөрөлтэй эмийн сангийн эмийн эргэлт, худалдан авалтад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг чангатгах, эрчимжүүлэх;

4. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн бодис агуулагч ургамлын тархацын талаарх судалгааг тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын албадтай хамтран зохион байгуулж, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан ургамлын тархац, төрлийг нарийвчлан тогтоож, зураглалыг нууцын зэрэглэлтэйгээр гаргах, орон нутгийн байгаль орчны албатай хамтран жил бүр тухайн ургамлын тархацтай бүс нутгийг шинэчлэн тогтоож, байнгын устгал хийх ажлыг тогтмолжуулах;

5. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлд донтох нь хэрэглэгчийн хувьд өвчин тул донтой хүнд олон улсын жишиг, туршлагын дагуу олон талт эмчилгээ хийх бололцоо нөхцлийг бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллага үйл ажиллагаагаа чиглүүлэх;

6. Зүүн өмнөд Азийн улс орнуудын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагатай харилцаа холбоо тогтоож, мэдээ, мэдээлэл солилцохоос гадна хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Монгол иргэд олноор зорчиж, сурч ажиллаж, амьдарч гэмт хэрэгт холбогдож байгаа БНХАУ-ын Бээжин болон Хонконг, Макао, Эрээн, Хөх хот, Малайзын Куала Лампур, ОХУ-ын Улаан-Үд, Москва, Унгар улсын Будапешт, Солонгос улсын Сөүл, Турк улсын Анкара зэрэг улсуудад Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яаманд гэмт хэрэгт хохирсон болон холбогдон шалгагдаж байгаа өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, улс дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ижил төстэй байгууллагуудын хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн атташе томилон ажиллуулах.

8. ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн алба, БНХАУ-ын НАХЯ-ны ХЦУГ-ууд улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлдэг. Боомтын асуудлаар үүссэн аливаа асуудлыг хилийн төлөөлөгчийн шугмаар шийдвэрлэдэг байхаар хилийн дэглэмийн гэрээгээр зохицуулсан. Гэтэл хилийн боомтын хуулиар улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх чиг үүргийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагад шилжүүлснээр боомтоор гарсан зөрчлийг хилийн төлөөлөгчийн шугмаар таслан зогсоох, урьдчилан сэргийлэх бус зөвхөн мэдээлэл солилцох хэмжээнд ажиллах болсон нь ихээхэн учир дутагдалтай. Иймд олон улсын жишиг, хил залгаа улсын ижил чиг үүрэг бүхий шалган нэвтрүүлэх байгууллагуудын бүтэц тогтолцоо, хилийн нөхцөл байдал, улсын хил хамгаалах байгууллагын чадавхи, нөөц бололцоо, туршлагыг нь харгалзаж, хилийн боомтын шалган нэвтрүүлэх чиг үүргийг Хил хамгаалах байгууллагад шилжүүлснээр энэхүү гэмт хэргийн тээвэрлэлтийг зогсоох бүрэн бололцоотой гэж үзэж байна.

9. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэсэн зүйл заалтын дагуу энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд 15 жил хүртэл хорих ялаар шийтгэх, ялангуяа идэвхитэй хэрэглэж буй 16-35 насны залуучуудад тавих хяналтыг идэвхжүүлж, эрх зүйн боловсролыг олгох шаардлагатай.

10. Монгол Улсын иргэд ихээр зорчдог, дэлхийд хар тамхи мансууруулах бодисын хууль бус сүлжээ үүсгэн идэвхитэй ажиллаж буй Казакстан, БНХАУ, Сингапур, Хонгконг, Тайланд, Лаос зэрэг орон руу зорчиж буй иргэдэд тавих хяналт шалгалтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

11. ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн алба, БНХАУ-ын НАХЯ-ны ХЦУГ-ууд улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлдэг. Боомтын асуудлаар үүссэн аливаа асуудлыг хилийн төлөөлөгчийн шугмаар шийдвэрлэдэг байхаар хилийн дэглэмийн гэрээгээр зохицуулсан. Гэтэл хилийн боомтын хуулиар улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх чиг үүргийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагад шилжүүлснээр боомтоор гарсан зөрчлийг хилийн төлөөлөгчийн шугмаар таслан зогсоох, урьдчилан сэргийлэх бус зөвхөн мэдээлэл солилцох хэмжээнд ажиллах болсон нь ихээхэн учир дутагдалтай. Иймд олон улсын жишиг, хил залгаа улсын ижил чиг үүрэг бүхий шалган нэвтрүүлэх байгууллагуудын бүтэц тогтолцоо, хилийн нөхцөл байдал, улсын хил хамгаалах байгууллагын чадавхи, нөөц бололцоо, туршлагыг нь харгалзаж, хилийн боомтын шалган нэвтрүүлэх чиг үүргийг Хил хамгаалах байгууллагад шилжүүлснээр энэхүү гэмт хэргийн тээвэрлэлтийг зогсоох бүрэн бололцоотой гэж үзэж байна.

12. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэсэн зүйл заалтын дагуу энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд 15 жил хүртэл хорих ялаар шийтгэх, ялангуяа идэвхитэй хэрэглэж буй 16-35 насны залуучуудад тавих хяналтыг идэвхжүүлж, эрх зүйн боловсролыг олгох шаардлагатай.

13. Монгол Улсын иргэд ихээр зорчдог, дэлхийд хар тамхи мансууруулах бодисын хууль бус сүлжээ үүсгэн идэвхитэй ажиллаж буй Казакстан, БНХАУ, Сингапур, Хонгконг, Тайланд, Лаос зэрэг орон руу зорчиж буй иргэдэд тавих хяналт шалгалтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.